

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН БА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- 2024 онд хүний нөөцийн хувьд Гүйцэтгэх захирал-1, нягтлан -1, веб админ – 1 гээд үндсэн 3 ажилтан ажиллалаа.
- Сайтын хувьд өдөр бүр тасралтгүйгээр мэдээллээ шинэчлэн ажиллаж мэдээний бичлэгийн чанар сайжруулах, мэдээний тасралтгүй байнгын урсгалыг ханган сайтын хандалтыг нэмэгдүүлэхийг чухал зорилт болгон ажилласан.
- Одоо ажиллаж байгаа Оллоо веб сайтын 5-р хувилбар ашиглалтын явцад засаж сайжруулах ажлууд гарж байгаа тухай бүр нь засваруудыг хийж сайтын найдвартай жигд ажиллагааг хангаж ажилласан.
- Өнөөдрийн байдлаар www.olloo.mn вебсайтын Фэйсбүүк хуудас маань 117.1k like-тай, 136.0k дагагчтай, twitter хуудас маань 18.5k дагагчтайгаар ажиллан, вебсайтад нийтлэгдсэн мэдээ мэдээлэл давхар түгээгдэн ажиллаж байна
- 2024 онд хийгдсэн хамтран ажиллах гэрээнүүд

Эхлэх огноо	Дуусах огноо	Байгууллагын нэр	Гэрээний утга
2024.01.24	2025.01.24	Голомт банк	Ажил гүйцэтгэх гэрээ
2025.01.15		Нийслэл аудит	Санхүүгийн тайлангийн аудитийн гэрээ

- Санхүүгийн хувьд 2024 онд Нийт жилийн орлого 16.6 сая төгрөг ба 14.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Санхүүгийн тайланг аудитийн дүгнэлтийн хамт хавсаргаж явуулав.

• 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд мэдээний бичлэгийн чанар сайжруулан, сайтын хандалтыг нэмэгдүүлэх нь энэ жилийн хувьд хамгийн чухал ажил зорилт байх болно. Гадаад хэлний орчуулгын мэдээний чанарт анхааран ажиллаж, өөр хэвлэл мэдээлэлд орчуулагдаагүй шинэ содон мэдээг орчуулж уншигчидад хүргэнэ.

Оллоо веб сайтын 6-р хувилбарыг технологийн бүх төрлийн шаардлага хангасан хөрвөх чадвартайгаар хийн ашиглалтанд оруулах зорилготой ажиллаж байна.

"Оллоо" фэйсбүүк хуудсыг идэвхитэй хөгжүүлэн, мэдээ мэдээлэл, үйл явдалыг түргэн шуурхай LIVE хийж дамжуулах, өдөр бүр 1 мэдээг онцлон boost /мөнгө төлөн илүү олон хүнд хүргэх/ хийнэ